



МОНГОЛ УЛСЫН
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

Барилгын нэг маягийн бүтээц,
эдлэхүүний цуврал зургийн
цомог батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо"-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн 2024 оны 05 дугаар хурлын 05-03/2024 дугаар шийдвэрийн дагуу барилга, Байгууламжийн норм, нормативын баримт бичиг "Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын өөрөө нягтрах, хүнд бетоноор үйлдвэрлэх төмөр бетон пирамид шонгийн нэг маягийн бүтээц, эдлэхүүний цуврал зургийн цомог /Г2.404.1-1Г", "Тасралтгүй хэвлэх аргаар үйлдвэрлэх өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын хөндийт трапец төмөр бетон шонгийн нэг маягийн бүтээц, эдлэхүүний цуврал зургийн цомог /Г2.404.2-1Г/-ийг тус тус хавсралт ёсоор баталж, 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Батлагдсан барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичгийг мөрдөж эхлэх хугацаанаас өмнө хэвлэн олшруулж холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд болон салбарын инженер техникийн ажилтнуудад мэдээлэл хүргэх, таниулах, сурталчлах, сургалт зохион байгуулахыг "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ /Т.Пүрэвхатан/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газар (Д.Гантулга)-г тус тус даалгасгай.



Ж.БАТСУУРЬ

1524010055